



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/52

Арвайхээр сум

**Буцалтгүй тусламж үзүүлэх тухай**

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах сувилгаа, хөдөлгөөн засалчийн чиглэлээр суралцаж буй Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн 6 дугаар курсын оюутан Бат-Оршихын Цэдэвсүрэнгийн сургалтын төлбөрт нийт 2,250,000 (хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх 2,250,000 (хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0112

D:My Doc. Zahiramj. Zasag darga